



НИСЭХ ЗАГВАРЫН СПОРТЫН 2021 ОНЫ УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

1. Ерөнхий зорилго

Энэхүү тэмцээн нь нийт ард түмэн, хүүхэд залуучуудад Нисэх загварын спортыг сурталчлах, сонирхогч тамирчдын эгнээг өргөтгөх, Монголын Нисэх загварын спортын нийгэмлэгийг сурталчлах, тамирчдаа алдаршуулах зорилготой.

Тэмцээний дүнгээр ангилал тус бүрт шилдгүүдийг шалгаруулж “Улаанбаатар хотын 2021 оны аварга” хэмээн өргөмжилнө.

2.Тэмцээнд оролцогчид, тэдгээрийн бүртгэл

2.1. Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд тэмцээний хураамж төлсөн хэн боловч оролцож болно. Тэмцээний хураамжийн хэмжээг “Тэмцээний хураамж” хэсэгт заав.

2.2. Тэмцээнд оролцогчдын мэдүүлгийг загварын дагуу бичгээр эсвэл электрон шуудангаар авна.

Электрон шуудангийн хаяг: secretary@masa.mn

Утас: 9995-7807 (Ц.Цацралт)

2.3. Тэмцээнд оролцогчдын мэдүүлгийг 2021 оны 05-р сарын 20-ний өдрийн 18.00 цаг хүртэл хүлээж авна.

2.4. Тамирчин хэдэн ч ангиллаар тэмцээнд оролцож болох ба нэмж оролцох ангиллын тэмцээний хураамж тус бүрийг 50 хувь хөнгөлж төлнө.

3. Тэмцээн явагдах төрөл, ангилал

- 3.1. Чөлөөт нислэгийн элин халих F1A ангилал
- 3.2. Чөлөөт нислэгийн резинэн хөдөлгүүрт F1B ангилал
- 3.3. Чөлөөт нислэгийн хугацаат нислэгийн F1C ангилал
- 3.4. Чөлөөт нислэгийн элин халих F1H ангилал
- 3.5. Чөлөөт нислэгийн резинэн хөдөлгүүрт F1G ангилал.
- 3.6. Жолоодлогот уран нислэгийн F2B ангилал.

3.7. Радио удирдлагат уран нислэгийн F3A ангилал

3.8. Радио удирдлагат агаарын тулалдаан RCC ангилал

4. Тэмцээн болох газрын байршил

Тэмцээн нь 2021 оны 05-р сарын 22, 23-ны өдрүүдэд Чөлөөт нислэг, Радио удирдлагат загварын төрлүүдээр Налайх дүүргийн Дархан ноёны худаг хэмээх газар, Жолоодлогот загварын төрлөөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэн дэх MASA кордодром дээр явагдана.

5.Тэмцээний хураамж

Тэмцээнд оролцогчид тэмцээний хураамж төлсөн байх ба хураамж нь МАСА нийгэмлэгийн татвар төлсөн гишүүдийн хувьд 30,000 төгрөг байх ба МАСА нийгэмлэгийн татвар төлөөгүй гишүүд, мөн нийгэмлэгийн гишүүн бус тамирчид дээр зааснаас 2 дахин илүү хэмжээний хураамж (60,000 төгрөг) төлж, тухайн тэмцээнд оролцох эрх авна.

18 нас хүрээгүй өсвөр насны тамирчдын хураамж 10,000 төгрөг байна.

Тэмцээнд гадаад орны тамирчид оролцохдоо 30 ам.долларын хураамж төлнө.

Тэмцээний хураамжинд хоол, унааны зардал багтаагүй болно.

Тэмцээний хураамжийг 2021 оны 05-р сарын 20-ний өдрийн 18.00 цаг хүртэл хүлээж авна.

Хураамж төлөх данс: Хаан банк 5016805242

Данс эзэмшигч: Монголын Нисэх загварын спортын нийгэмлэг

Гүйлгээний утга: Овог нэр, оролцох ангилал, утасны дугаар

6. Тэмцээний хуваарь

2021 оны 05-р сарын 22-нд

Дархан ноёны худагт

06:00-07:00 1-р үе Чөлөөт нислэгийн F1A, F1B, F1C, F1H, F1G

07:00-08:00 2-р үе

08:00-09:00 3-р үе

09:00-10:00 4-р үе

10:00-11:00 5-р үе

11:00-12:00 6-р үе Дурсгалын зураг авахуулах

12:00-13:00 7-р үе

13:00-14:00 Үдийн цайны завсарлага

14:00-16:00 Радио удирдлагат агаарын тулалдаан RCC ангилал

2021 оны 05-р сарын 22-нд

Үндэсний цэцэрлэгт хүрээлэн дэх MASA кордодром дээр

08:00 1-р үе Жолоодлогот уран нислэгийн F2B ангилал

Дархан ноёны худагт

09:00 1-р үе Радио удирдлагат уран нислэгийн F3A ангилал

18:00-17:00 Шагнал гардуулах ёслолын ажиллагаа

Гарааны тоог оролцох тамирчдын тооноос хамааруулан урьд өдөр жич зарлана.

Зарим ангиллын тэмцээн эхлэх цагийг тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан өөрчилж болно.

7.Тэмцээн явуулах, шалгаруулах

7.1. Тус тэмцээнийг Дэлхийн Агаарын Спортын Холбоо FAI-ын (Federation Aeronautique Internationale) дүрэм, Монгол Улсын НЗС-ын нэгдсэн ангиллын дүрмээр явагдана.

7.2. Цаг агаарын хүндрэлтэй нөхцлийн үед шүүгчдийн шийдвэрээр тэмцээний цагийг зохицуулна.

7.3. Загварын ангилал тус бүр дээр тамирчдыг хувийн дүнгээр байр эзлүүлнэ.

- I байр - Улаанбаатар хотын 2020 оны аваргын диплом, алтан медаль
- II байр - диплом, мөнгөн медаль
- III байр - диплом, хүрэл медаль

8.Материал техникийн болон бусад хангамж.

8.1. Шүүгчдэд УЗ-ийн шийдвэрт зааснаар ажлын хөлс олгоно.

8.2. Тамирчдад бэлтгэлийн болон тэмцээний нислэгийн түлшийг аль ч төрөлд олгохгүй.

8.3. Тэмцээний үеэр аюулгүй байдлыг хангаж машин байрлуулах, бэлтгэл хийж болохгүй бүсийг зааж өгнө.

8.4. Тамирчид дүрэмд заасан аюулгүйн арга хэмжээ авч, заагдсан тохиолдолд хамгаалах хэрэгсэл заавал хэрэглэнэ.

9. Эсэргүүцэл, гомдол гаргах тухай

9.1. Тэмцээний явцад маргаантай байдал үүссэн тохиолдолд багийн ахлагч (хувиараа оролцож байгаа тамирчин) тэмцээний ерөнхий шүүгчид эсэргүүцэл гомдол гаргах эрхтэй.

9.2. Эсэргүүцэл гомдлыг бичгээр, зөрчигдсөн гэж үзэж байгаа дүрэм зааврын зүйлийг зааж гаргана.

9.3. Эсэргүүцэл гомдолд тухайн тэмцээний хураамжийн 50%-тай тэнцэх барьцааг заавал хавсаргана. Энэхүү барьцааг эсэргүүцэл гомдол нь үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд буцаан олгогдох ба үндэслэлгүй гэж үзвэл тэмцээний хураамж бүрдүүлэлтэнд нийлүүлж тэмцээн зохион байгуулах ажилд зарцуулна.

10. Тэмцээний дэг журам, сахилга батын тухай

10.1. Тэмцээний үр дүнг сайжруулах, тамирчдын хувийн амжилтыг дээшлүүлэхийн тулд шүүгч, тамирчдыг тэмцээний хугацаанд согтууруулах ундаа хэрэглэхийг хориглоно.

10.2. Дээрх журмыг зөрчсөн тамирчныг тэмцээнээс хасах хүртэл арга хэмжээ авна.

10.3. Дээрх журмыг зөрчсөн шүүгчид цалин олгохгүй, тэмцээн шүүх эрхийг 1 жил хүртэл хугацаагаар хасах арга хэмжээ авна.

11. Шүүгчдийн бүрэлдэхүүн

11.1. Тэмцээний Ерөнхий шүүгч болон төрөл болгоны ахлах шүүгчдийг тэмцээний Ерөнхий зохион байгуулагч томилно.

11.2. Тамирчин нь өөрөө оролцохгүй төрөлдөө шүүгч хийх эрхтэй ба урьдчилан мэдэгдэх шаардлагатай /2021 оны 05-р сарын 20-ноос өмнө/

11.3. Шүүгчийн зэрэглэл нь НАЗ-аас олгосон үнэмлэхээр баталгаажаагүй тохиолдолд зэрэггүй шүүгчээр цалин олгоно.

12. Зохион байгуулагч

12.1 Тэмцээний ерөнхий зохион байгуулагч Ц.Цацралт (утас: 9995-7807),
F2 төрлийн зохион байгуулагч Ж.Баттөгс (утас: 8811-9187)

Тэмцээний үеэр Улсын онцгой комиссын тогтоосон ариутгал, халдваргүйн дэглэмийг чанд сахихыг анхааруулж байна!

Монголын Нисэх Загварын Спортын Нийгэмлэг